

## **ХОВД, БУЯНТ ГОЛЫН САВ ГАЗРЫН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ/АЖЛЫН УДИРДАМЖ**

### **А. Уур амьсгал, цаг уур**

- Дэлхийн бөмбөрцөгийн хойд хэсгийн цаг уур/уур амьсгалын хэв шинж (товчоор)-ийг ялангуяа Монгол улсын баруун бүсийн уур амьсгал/ цаг ууртай холбож тодорхойлох;
- Уур амьсгал/цаг уурын нөхцөл байдал (өнгөрсөн, одоо, ирээдүй) –ыг тодорхойлж дүн шинжилгээ хийх;
- Гол чиглэл нь (гарсан, гарч буй, гарах өөрчлөлтийг тодорхойлон)
  - o Хур тунадас + жилийн турш орох нийт хур тунадас мм-ээр; (өнгөрсөн, одоо, ирээдүй 2015, 2030 он);
  - o Агаарын хэм: жилийн турш; (өнгөрсөн, одоо, ирээдүй 2015, 2030 он);
  - o Үүл: жилийн турш; (өнгөрсөн, одоо, ирээдүй 2015, 2030 он);
  - o Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа;
  - o Гол усны хөлдөлт\мөстөлтийн үе, голын ул хэсгийн мөсний зузаан;
- Газрын зураг, хүснэгтээр харуулсан мэдээлэл (зөвхөн гол мөрний сав газраар);
- Ус цаг уурын хүрээлэн, Ховдын их сургуулиас гаргасан мэдээ баримтын тайлбар, ашиглалт;
- Өнгөрсөн хугацаа (1950-аад оноос хойш одоог хүртэл)-нд хийсэн судалгаа, ажиглалтын мэдээ баримтын ашиглалт, хэрэв байхгүй бол өнгөрсөн үеэс одоог хүртэлх хугацаанд байсан ерөнхий чиг хандлагыг харуулах.
- Гол мөрний сав газруудын хэмжээнд (мөн сав газрын хилээс гадагш 50 км-т) одоогийн байгаа (болон өмнө байсан) ус цаг уурын станциуд байршлыг харуулсан газрын зураг;

### **Б. Геологи, физик газар зүй, хөрс**

- Голын сав газрын физик газар зүй, хөрсний төрөл, геологийн ерөнхий тодорхойлолт, газрын зургууд.
- Өндөрлөг/өргөрөгийг харуулсан газрын зураг;  
1:100.000 масштаб бүхий газрын зураг; ГЗМС-д үндэслэсэн?  
Боломжтой бол геологийн ямар бүтэцтэй, хөрсний ямар төрлүүд байдаг талаар мэдээлэл өгөх, тухайлбал:
  - Усаар дахин сэлбэгдэх коэффициент (хөрсөнд шингэж нэвтрэх) (хур тундасны хэдэн хувь нь хөрсөнд шингэж, хэдэн хувь нь ууршиж алга болж байгаа);
  - Урсацын коэффициент (хэдэн хувь нь шууд голын сав газарт эргэж урсац болж байгаа);
  - Эсвэл эргэж усны урсац болохгүй байна уу эсвэл хөрсний усны давхрага (гүний усны хадгалалт)-т очиж байгаа болон хөрсний усны зузаан хэдэн метр байгааг тодорхойлох;
- Голын сав газарт ордог, тэдгээрийг тэтгэж байдаг мөсөн голуудын тодорхойлолт, нэр, тоо ;
- Усны хөрсөнд шингэдэг ба усны илүүдэл бүхий газруудын тодорхойлолт
- Булаг шанд бүхий газруудын тодорхойлолт, байршил;

## **В. Усны систем/тогтолцоо – томоохон хэмжээний дэд бүтэц**

усны систем/тогтолцоо, нийгэм эдийн засгийн тогтолцоог ерөнхийд нь тодорхойлох;

- Нуурын далан, хаалт, голын голидролын өөрчлөлт/ хазайлт, ус ашиглалт, суваг шуудуу зэрэг “томоохон” хэмжээний дэд бүтцийн тодорхойлолт;
- Усны бага хэмжээний бус харин томоохон хэмжээний ашиглалт ( $> \dots \text{m}^3/\text{s}$ );
- Жишээ нь байрлал (байршил тогтоогч /GPS/ ашиглан + газрын зурагт оруулсан) боломжтой бол хүчин чадал/багтаамж  $\text{m}^3$ :
  - Усан цахилгаан станцийн далан;
  - Гол мөрөнд барьсан бусад далан хаалт
  - Ус дамжуулах хоолой (жишээ нь: Буянт голоос Ховд хот руу татсан хоолой)
  - Ус ашиглах зорилгоор усны голидрол өөрчилсөн цэгүүд:
    1. Газар тариаланг усжуулах зорилгоор,
    2. Хадлангийн талбайг усжуулах зорилгоор,
    3. Мод үржүүлгийн газрыг усжуулах зорилгоор,
    4. Бусад зорилгоор усжуулах зорилгоор хийсэн газрууд.
  - Хөрсний ус-ашиглалт- худаг ус (төв буюу орон нутгийн иргэд буюу арилжааны зориулалтаар ашигладаг худагны байршил, тэдгээрийн хүчин чадал); боломжтой бол худаг бүрийн мэдээллийг газрын зурагт оруулах, гэхдээ энэ нь голын сав газрын нэгдсэн менежментийн анхны төлөвлөгөөний хувьд шаардлагагүй; худаг усны төвлөрөл ( $> 50$ )-ийг багц болгон газрын зурагт оруулж болно;
  - Гол усанд барьсан бетон, төмөр, модон гүүрүүд (мөн бусад хаалт)-ийн байршил
  - Үер уснаас хамгаалах зорилгоор барьсан хаалт, далангууд (? Ховд/Буянт голуудад байдаггүй)
  - Ус дамжуулах суваг шуудуу/ хоолой (?Ховд/Буянт голуудад байдаггүй)

## **Г. Гидрологич – усны систем/тогтолцоо – тоо хэмжээ ( $\text{m}^3$ , усны тоо хэмжээ, тооцоо гэх мэт),**

- Голын сав газрын гидрологийн мэдээ баримтыг цуглуулах зорилго бүхий станциудыг газар зүйн байршил тогтоогч-GPS ашиглан гаргасан газрын зураг;
- Голын сав газрын хэмжээнд голын сигмент бүр (10-50 км бүрт)-ээр ус гадагшуулж буй хэмжээ  $/\text{m}^3/$ -г харуулах (газар зүйн байршил тогтоогч-GPS ашиглан газрын зурагт), усны урсалын хазайлт/өөрчлөлт бүрт байгаа усжуулалт/ ус ашиглалт, хэрэглээ  $/\text{m}^3/$ ;
- Голын сав газрын хэмжээнд байгаа мөсөн гол, гол мөрөн, газрын гүн дэх усны хадгалалтын тодорхойлолт  $/\text{m}^3$  эсвэл  $\text{km}^3$  –ээр/;
- Тодорхой хугацаа (жилийн болон сүүлийн 20 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт)-нд гол уснаас хэдий хэмжээний ус гадагш урсаж байгаа талаар тоо мэдээ баримт;
- Үндсэн ба тэтгэгч голууд ( $> 25$  км урт)-ын усны эхээс төгсгөлийн цэг хүртэлх далайн түвшиний өндөрлөгийн схем/график;
- Ууршилт – гүний/гадаргуугийн уст цэгүүдийн тоо, усаар нөхөн сэлбэгдэх коэффициент;
- Гол мөрний усны хэмжээ;

- Экологи, нийгэм эдийн засгийн хамааралтай гол усны тодорхойлолт;

Голын сав газрын зөвлөл/Голын сав газрын нэгдсэн менежментийн асуудлаар уншдаг хүмүүст хэрэг болох техникийн гидрологийн нарийвчилсан мэдээ баримт гаргахад хүндрэл гарч болно.

#### **Д. Усны систем/тогтолцоо – чанар**

Усны чанар бол тусд нь онцгойлон авч үзэх асуудал юм. Усны чанарын асуудлыг зөвхөн ажиглалт/судалгаа хийх замаар тодорхойлох бус харин зарим тохиолдолд лабораторийн дүн шинжилгээ хийх хэрэгтэй болдог.

Ховд, Буянт голын сав газрын хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа харьцангуй бага явагддаг, хүн амын нягтшил ( $\text{km}^2/\text{оршин суугчийн тоо...}$ ) бага байна. Гэсэн ч Голын сав газрын нэгдсэн менежмент/ Голын сав газрын зөвлөлийн оролцоотой шийдэх усны чанарын хэд хэдэн асуудлууд байсаар байна.

Ялангуяа Ховд, Буянт голууд нь Алтай Саяаны эко-бүсд экологийн өндөр ач холбогдолтой байдгийн хувьд усны чанарын асуудлыг чухалчлан авч үзэх хэрэгтэй.

Яагаад усны чанар чухал асуудал болдог вэ? Учир нь:

- Хүн, мал, ан амьтны эрүүл мэндэд чухал нөлөө үзүүлдэг;
- Экологи, ан амьтдын амьдрах орчны тааламжгүй байдал, ан амьтад (жишээ нь: загас, усны шувууд, хөхтөн гэх мэт) –ын амьдрах чадварт нөлөө үзүүлдэг;
- Бохирдсон газрууд/усны нөөцийг нөхөн сэргээхэд шаардлагатай зардалд нөлөө үзүүлдэг;
- Ландшафтын чанарт нөлөө үзүүлдэг.

Түүнчлэн олон нийтийн мэдээлэл сурталчилгаа нь чухал механизмын нэг байна.

Усны чанарт үзүүлэх нөлөө нь орон нутгийн хэмжээнд (жишээ нь: хөрс эсвэл хөрсний ус, нуурын бохирдол) байгаа ч эдгээр бохирдол нь жижиг гол, горхиор дамжин Хар ус нуур болон бусад гол усанд гэнэт тархаж болно.

Нэг талаас усны чанарын асуудал нь өөрөө ерөнхий нэгдсэн арга барилыг шаарддаг ч нөгөө талаас орон нутгийн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авахыг шаарддаг.

Голын сав газрын нэгдсэн менежментийн хувьд ойрын хугацаанд дараах асуудлаар ерөнхий тойм гаргах хэрэгтэй. Үүнд:

- Тодорхой газар нутгийн хэмжээний бохирдол (эрсдэл), хаягдал ус, хатуу хог хаягдал;
- Үйлдвэрлэлийн бохирдол (эрсдэл) түүнчлэн өмнө ажиллаж байсан үйлдвэрийн газрууд орчмын бохирдол;
- Уул уурхайн бохирдол (эрсдэл)

- Хөдөө аж ахуйн бохирдол (эрсдэл) тухайлбал химийн бодис, хортон шавьж устгах хор гм

Орон нутагт байгаа бохирдлын хувьд “цэвэршүүлэх” буюу ариутгах талаар Өлгий (Ховд голын дунд хэсэг), Ховд (Буянт, Ховд голын адаг) гэсэн 2 хотын хувьд авч үзэж ирсэн; цаашид цэвэршүүлэх, ариутгах ажиллагааг 2.000-10.000 хүн ам бүхий төв суурин газар; 25-2.000 хүн ам бүхий суурин; 1-25 хүн бүхий гэр, орон байрны хэмжээнд авч үзэх болно;

Голын сав газрын нэгдсэн менежментийн хувьд дараах асуудлыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- ерөнхийдөө: голын сав газрын хэмжээнд гүний ус, хөрс, гадаргын ус (нуур/гол мөрөн)-ыг бохирдуулах бүх эх үүсвэрийг судалж тогтоох газрын зураг (GPS/ГЗМС-т үндэслэсэн)-т харуулах; дараах зүйлийг илүү нарийвчлан авч үзэх, үүнд:
  - Бохир усны систем (хүчин чадал, түүнтэй холбогдсон байшин барилгын тоо)-ийг оруулсан “ус цэвэршүүлэх” 2 үйлдвэрийн байршил, тодорхойлолт, үнэлгээ);
  - Өмнө байсан болон одоо байгаа хатуу хог хаягдлын байршил (төвлөрөл)-ын тухай тойм;
  - Бохир усны цооногуудын байршил, төвлөрлийн тухай тойм;
  - Өмнө байсан + одоо байгаа үйлдвэрийн газруудын байршил (боломжтой бол бохирдсон хөрс, гүний усны тойм)-ын тойм;
  - Голын сав газрын хэмжээнд өмнө байсан, одоо байгаа, ирээдүйд төлөвлөж буй уул уурхай бүхий газруудын тойм, гарч болох бохирдлын эрсдэл (химийн бодис хэрэглэдэг хэрэглэх эсэхийг тодорхойлох);
  - Өмнө байсан, одоо байгаа болон цаашид төлөвлөж буй жижиг хэмжээний арилжааны үйл ажиллагаа (үйл ажиллагааны төрлүүд, гарч болох бохирдлын эрсдлүүд);
  - Өмнө байсан, одоо байгаа болон цаашид төлөвлөж буй хөдөө аж ахуй/бэлчээр ашиглалт мөн химийн бодис, хортон шавьж устгах бодисын хэрэглээ болон хэтрүүлэн ашиглаж болох талаар ерөнхий тойм өгөх;

#### **Е. Экологи + Экологи, ус**

- Сав газрын биологийн төрөл зүйл, экологийн үнэ цэнийн талаар ерөнхий тодорхойлолт гаргах (ургамал, амьтны зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчин);
- Голын сав газрын хэмжээнд экологийн ямар бүсүүд байдаг; Байгалийн төлөв байдлын чанар ямар хэмжээнд байгаа, хүний үйл ажиллагааны улмаас хэрхэн өөрчлөгдөж, сүйтгэгдэж байна?
- Сав газрын ховор ба ховордсон амьтан ургамлын зүйлүүд, тэдгээр нь усны нөөц (чанар, ашиглалт)-тэй хэрхэн холбоотой байдаг;
- Уснаас хамааралтай загас, хоёр нутагтан, мөлхөгчид, усны шувууд зэрэг экологийн чухал ач холбогдолтой тухайлбал зүйлүүд/амьдрах орчинд онцгой анхаарлаа хандуулах; эдгээрээс аль зүйлүүд нь жижиг орчинд амьдарч, ямар зүйл (жишээ нь: нүүдэллэдэг загас)-үүдэд голын дагуу экологийн коридор хэрэгтэй;
- Усны хомсдол, ус ширгэх хатах, булаг шанд алга болох, цэвдэгшил/мөсөн голууд хайлснаар амьтан ургамлын зүйлүүд/ амьдрах

орчинд ямар нөлөө үзүүлэх? Холбогч голуудын байнгын/байгалийн урсацаас ямар зүйлүүд хамааралтай буюу түр зуурын холбогч голууд нэг жилд буюу 2-3 жилд нэг удаа байх нь хангалттай юу?

- Усны чанар дээшилж, холбогч голуудын усны түвшин дээшлэх нь экологи (аль зүйлүүд/амьдрах орчин)-т хэрхэн нөлөөлөх вэ?;
- Голын сав газрын хэмжээнд аль газрууд/цэгүүд нь экологийн хувьд илүү чухал, аль газрууд/цэгүүдэд (усны асуудалтай холбоотой) аюул нүүрлээд байна вэ?;
- НҮБХХ-ийн биологийн төрөл зүйл төсөл, Ховдын их сургуулийн Экологийн танхимтай хэрхэн хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах.

## **Ё. Нийгэм эдийн засгийн хөгжил – хөдөө аж ахуй/ уул уурхайг оруулахгүйгээр**

- Нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудалтай холбож нэн тэргүүний асуудлаа тодорхойлж, зураг (GPS, газрын зураг)-г харуулах

### **A Нийгэм эдийн засгийн тогтолцоо**

- Хүн ам, түүний өсөлт, үндэстэн ястнууд, шилжилт хөдөлгөөн,
- Түүхэн хөгжил
- Хотжилт, хүн ам сууршилт, улирлын нүүдэл/ шилжилт хөдөлгөөн
- Бүс нутгийн эдийн засаг
- Орон зайн төлөвлөлтийн бодлого
- Хог хаягдал
- Аялал жуулчлал
- Үерийн усны менежментийн дэд бүтэц
- Байгалийн гамшиг (ойн түймэр, ган, үер ус гэх мэт)
- Ерөнхий газар ашиглалт
- Мал аж ахуй (уламжлалт ба эрчимжсэн)
- Хөдөө аж ахуй (усалгаатай ба усалгаагүй)
- Ойн аж ахуй
- Үйлдвэр
- Уул уурхай, ашигт малтмалын ордууд
- Гол дэд бүтэц (авто зам, төмөр зам, эрчим хүч, газрын тосны хоолой/шугам)
- Бусад ашиглалт

### **Б. Нийгэм эдийн засгийн харилцаа ба ус**

- Уснаас хамааралтай харилцааг тодорхойлох
- Ус ашиглалтын, усны хангамж/ эрэлт хэрэгцээний талаарх тоо баримт (салбар бүрээр), м3, усны өөрчлөлт/эргэлтийн тогтолцоо, тээвэрлэлт гэх мэт,
- Усны хангамжийн тогтолцоо: дотоодын ба үйлдвэрлэлийн
- Усжуулалтын тогтолцоо
- Гүний усны ашиглалт, худаг ус/татуурга, м3;
- Усан цахилгаан станцийн далан
- Үерийн далан
- Бохир/хаягдал ус боловсруулах, цэвэршүүлэх төхөөрөмж
- Усны төлбөр хураамж, үнэ, ус түгээх буюу боловсруулах төлбөр хураамжийн тогтолцоо
- Ариун цэвэр, хаягдал ус ялгаруулалт, боловсруулалттай холбоотой мэдээ баримт

## **Ж. Нийгэм эдийн засгийн хөгжил – хөдөө аж ахуй**

- а. Голын сав газрын хөдөө аж ахуйд ашиглаж байгаа байдлыг харуулсан зураглал, хаана/юунд:
- i. Хөдөө аж ахуй/мал маллагаанд ерөнхийдөө ашиглаж байгаа байдал;
  - ii. Байршил, т2-талбай, хүнсний ногооны тарихад
  - iii. Байршил, т2-талбай, хадлан бэлтгэлд
  - iv. Байршил, т2-талбай, мод, хүнсний ногоо тарихад;
  - v. Байршил, т2-талбай, мод тарихад.
  - vi. Малчдын улирлаар ашигладаг талбай (улирал бүрээр ашигладаг газрууд байнгын болон түр хугацаагаар байрладаг гэр байшингийн байршлын хамт харуулсан газрын зураг);
  - vii. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор гол усны чиглэлийг өөрчлөн барьсан суваг шуудууны зураг, тэдгээрийг барьсан он сар өдөр, жилд дундажаар ашигласан тооцоо т3, т3/т2;

## **3. Нийгэм эдийн засгийн хөгжил – уул уурхай**

Уул уурхайн үйл ажиллагаа нь усны чанар, хэмжээ, гүний ба гадаргын усны нөөцөд эрсдэл учруулах шинэ салбарын нэг болоод байгаа тул ялангуяа голын сав газрын хэмжээнд өнөөгийн явагдаж буй ба цаашдын төлөвлөж буй уул уурхайн үйл ажиллагаанд онцгой анхаарал тавих хэрэгтэй байна.

Дараах асуудлуудыг тодорхойлох хэрэгтэй. Үүнд:

- Голын сав газрын дотор болон сав газрын хилээс гадна 50 км-т байгаа ашигт малтмалын ордууд (нэгэнт нийтийн өмч учраас мэдээлэл/зургууд олон нийтэд нээлттэй байлгах) (Монгол орны хэмжээнд) учир нь голын сав газрын гадна явуулж буй уул уурхайн үйл ажиллагаа ч гэсэн гүний усаар дамжин голын тухайн сав газарт нөлөө үзүүлдэг; байршлыг газрын зурагт харуулж, тайлбарыг текстээр өгөх;
- Голын сав газар болон түүний ойролцоо газруудад өнгөрсөн хугацаанд, одоо явагдаж буй, цаашид төлөвлөж буй уул уурхайн үйл ажиллагаа (зөвшөөрөлтэй эсэхийг судлах)-ны талаар ерөнхий тойм өгөх; одоогийн явагдаж байгаа болон төлөвлөж буй уул уурхайн үйл ажиллагаа, хайгуул хийж эхлэх хугацааг оруулах;
- Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй гүний ба гадаргын усны хэмжээ, ашигласан усаа хэрхэн гадагшлуулдаг, гаргаж буй усны чанар ямар байгааг тодорхойлох;
- Голын сав газрын зөвлөл/Гол мөрний сав газрын нэгдсэн менежментийн асуудлыг сонирхон уншдаг хүмүүст өнөөгийн уул уурхайн үйл ажиллагаа, түүний төрөл, үзүүлэх нөлөөллийн талаар ерөнхий тойм өгөх;

Үр дүн: Бүлэг 3 Н хэсэг, 3 (дээд тал нь 6) хуудас бүхий үндсэн хэсэг, ерөнхий мэдээлэл бүхий дээд тал нь 30 хуудас бүхий тайлан; 1 нэгдсэн газрын зураг;

## **К. Гидрологич – усны ашиглалт/эрэлт хэрэгцээ, тооцоо дүн шинжилгээ**

Өмнөх хэсэгт өгсөн мэдээлэлд үндэслэн усны ашиглалт/эрэлт хэрэгцээний талаар ерөнхий тойм тооцоо хийж болно.

Гол параметр/хэмжигдэхүүнд дараах зүйл орно. Үүнд:

- Гадаргын ус (гол мөрөн/нуур)-ны ашиглалт /м<sup>3</sup>/: хадлангийн талбай, усжуулалт, хот суурин газрын усны хэрэглээ (эдгээр үйл ажиллагаа нь бүгд байгалийн нөхцөл байдлаас ялгаатай өөр)
- Ус (гадаргын/гүний)-ыг үйлдвэрлэлд ашиглах /м<sup>3</sup>/, үйлдвэрээс гарч буй хаягдал ус;
- Усны дотоодын ашиглалт (гүний ус, худаг буюу голын ус) нэг хүнд ноогдох дундаж хэмжээ (газар дээр нь хийсэн зарим судалгаа, ажиглалтын үр дүнд үндэслэн, том ба жижиг суурин газруудын оршин суугчдын хэдийн хэмжээний ус хэрэглэдгийг судлан)-нд үндэслэн тооцож гаргах;

#### **Л. Гидрологич – усны нэгдсэн баланс**

Усны ашиглалт/эрэлт хэрэгцээний зэрэгцээ

Гадаргын ба гүний усны хэмжээг ойролцоогоор тооцон гаргаж болно. Боломжтой бол дэд салбар газраар эсвэл аймаг/сумаар нь нарийвчлан гаргах;

Усны загварчлал болон хангалттай тоо баримт, мэдээ (дутагдалтай) байхгүй байна. Эхний тооцоогоор ойролцоо, тойм тооцоо хийж болно. Ер нь хүн ам хэрхэн өсөх, нэг хүний ашиглах усны хэмжээ хэр зэрэг өсөх талаар урьдчилсан тооцоо хийж болно; энэ нь цаашид гарч болох хүндрэлтэй асуудал/аливаа сорилыг даван туулахад ерөнхий чиг баримжаа өгнө.

Түүнчлэн усны сигмент бүрээр түүний урсац/урсгалын доод хэмжээ (м<sup>3</sup>/сек)-г тодорхойлж болно;

#### **М. Сав газартай холбоотой хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалт, чадавхийн асуудалд дүн шинжилгээ хийх**

Ерөнхий эрх зүй/дүрэм журмын асуудлыг Бүлэг 2-т авч үзэх хэрэгтэй. Ус, байгаль орчны менежмент буюу орон зайн төлөвлөлтийн асуудалтай холбоотой одоогийн байгаа болон цаашид төлөвлөж буй аймаг (Зх), сумын зохицуулалт, бүтэц зохион байгуулалт, чадавхийн асуудлаар тусгайлан тайлан гаргах.

Усны нэгдсэн менежментэд тустай аймаг/сум бүрээр авч буй зохицуулалтын арга хэмжээний талаар ойлголт мэдээлэл өгөх тусгай хүснэгт гаргаж өгч болно. Тухайлбал: Ховд аймгийн хувьд энд Ховдын их сургуулийн ажилтнууд оролцож болно.

Өгч буй мэдээлэл бүхий текстийг хуулийн баримт бичгийн хэлбэрээр бус харин Голын сав газрын зөвлөлийн болон жирийн уншигч иргэдэд ойлгомжтой энгийн хэлээр бичигдсэн байх ёстой;